

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2025 оны 03 дугаар сарын ...-ны өдрийн А-... дугаар тушаалын хавсралт

БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмын зорилго нь Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.11-д заасны дагуу банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийг хангуулах, түүнд Монголбанкнаас хяналт шалгалт хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Банк зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, тогтоомж болон Банкны Хяналт шалгалтын Базелийн хороо (*цаашид “Базелийн хороо” гэх*)-ноос баталсан зохистой засаглалын зарчмыг удирдлага болгоно.
- 1.3. Монголбанк банкны зохистой засаглалыг хянан шалгахдаа банк нь банкны удирдлагын чиг үүрэг, эрсдэл, хяналт, аудитын тогтолцоо, үйл ажиллагааг энэхүү журмын 1.2-т заасан хууль, тогтоомж, зарчимд нийцүүлэн хэрэгжүүлж, биелүүлсэн эсэхийг энэ журмын хоёрдугаар дугаар бүлэгт заасан шалгууруудыг үндэслэн хянаж, гуравдугаар бүлэгт зааснаар үнэлж, дүгнэнэ.
- 1.4. Энэ журмын дагуу хянан шалгаж тогтоосон банкны удирдлага, зохистой засаглалд өгөх үнэлгээ, дүгнэлт нь Банкны тухай хууль тогтоомжид заасан хяналт шалгалт болон албадлагын арга хэмжээг банканд авах үндэслэл болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 2.1. Төлөөлөн удирдах зөвлөл (*цаашид “ТУЗ” гэх*) нь хадгаламж эзэмшигч болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах ба хувьцааны тоо хэмжээнээс үл хамааран нийт хувьцаа эзэмшигчдэд шударга, тэгш байдлаар хандана.
- 2.2. ТУЗ-ийг хангалттай тооны хараат бус гишүүдтэй байхаас гадна ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг банкны нарийн төвөгтэй асуудал, эрсдэлийг удирдахуйц эдийн засаг, хөрөнгийн зах зээл, санхүү, мэдээллийн технологи, стратеги, эрсдэлийн удирдлага, эрх зүй, засаглал зэрэг шийдвэр гаргахад шүүмжлэлтэй хэлэлцүүлэг өрнүүлэх, олон ургалч үзлийг дэвшүүлэх чадвартай, хүйсийн тэнцвэрт байдлыг хангахуйц холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу сонгогдсон гишүүдээр бүрдүүлнэ.
- 2.3. ТУЗ нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйл болон Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхтэй.
- 2.4. ТУЗ нь дараах бодлогын баримт бичиг, дүрэм, журам болон Зохицуулагч байгууллагаас шаардсан эрх зүйн актыг баталж хэрэгжилтэд тогтмол хяналт тавих үүрэгтэй. Үүнд:

- 2.4.1. Банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, жилийн санхүүгийн тайлан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (**ИСААР**), хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (**ИЛААР**);
 - 2.4.2. Банкны ажилтан бүрийн эрсдэлд хандах зохистой шаардлага, хандлага өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх эрсдэлийн соёлыг агуулсан үнэт зүйл, **ёс зүйн дүрэм**;
 - 2.4.3. Монгол Улсын хууль, тогтоомж болон зохицуулагч байгууллагаас тогтоосон дүрэм, журам, тушаал шийдвэр, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн болон зөрчиж болзошгүй үйлдлийг мэдээлэх, мэдээлэгчийг хамгаалах, мэдээллийн нууцыг хадгалах харилцааг зохицуулсан **шүгэл үлээх бодлогын баримт бичиг**;
 - 2.4.4. Банкны эрсдэлийн аппетит болон эрсдэлийн хязгаарыг бизнесийн стратеги, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлттэй уялдуулан тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих банкны **эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг**;
 - 2.4.5. ТУЗ-ийн ажлын алба нийт холбогдох этгээдүүдийн жагсаалт, тэдгээрт хамаарах зээл, зээлтэй адилтган тооцох актив, бусад хэлцлийн мэдээ болон **сонирхлын зөрчилтэй аливаа хэлцлийн** талаар баримтлах бодлогын баримт бичиг;
 - 2.4.6. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журам.
- 2.5. ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын мэдээллийг ТУЗ-ийн хурлаас 5 хоногийн өмнө авсан байна.
 - 2.6. ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хороодын дарга нь хараат бус гишүүн байх ба ТУЗ-ийн бусад хороонд харьяалагдахгүй. Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны бүх гишүүд нь хараат бус гишүүн байна.
 - 2.7. ТУЗ-ийн хараат бус гишүүнд сонгогдох этгээд нь 3 жилийн хугацаатай сонгогдох ба мөн хугацаагаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн дахин 1 удаа нэр дэвшүүлж болно.
 - 2.8. ТУЗ-ийн гишүүн тайлант хугацаанд саналын эрхтэй оролцдог ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хурлын ирц 75%-иас доош байгаа тохиолдолд улируулан сонгохоор нэр дэвшүүлэхгүй.
 - 2.9. ТУЗ нь Банкны тухай хуулийн 31.3.6-д заасны дагуу Дотоод аудит болон /комплайнс/ нийцлийн, эрсдэлийн удирдлагын хяналтын чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан нэгжүүдийг байгуулж, /CRO/ удирдах албан тушаалтныг томилно.
 - 2.10. ТУЗ нь банкны үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих зорилго бүхий дараах байнгын хороодыг байгуулна.
 - 2.10.1. Нэр дэвшүүлэх хороо;
 - 2.10.2. Цалин урамшууллын хороо;
 - 2.10.3. Аудитын хороо;
 - 2.10.4. Эрсдэлийн удирдлагын хороо.

- 2.11. ТУЗ-ийн хороод нь эрхлэх асуудлын хүрээнд ТУЗ-өөс баталсан тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, хууль, тогтоомжид заасан асуудлыг хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах бүрэн эрхтэй байна.
- 2.12. ТУЗ-ийн бүх хороод үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.
- 2.13. Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хуулийн 81.5 болон энэ журмын 2.13.1-2.13.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
 - 2.13.1. Банкны үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын орон тоо гэнэтийн байдлаар өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааны бодлогыг боловсруулж батлах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих;
 - 2.13.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг томилох санал, улируулан томилох саналыг гаргахдаа тухайн үйл ажиллагааг ил, тод, шударгаар хийж гүйцэтгэх;
 - 2.13.3. ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах шалгуурыг олон нийтэд нээлттэй зарлах буюу банкны цахим хуудсанд байршуулах, сонгон шалгаруулах үйл явцад хяналт тавих;
 - 2.13.4. Гүйцэтгэх удирдлагын тухайн жилийн ажлын гүйцэтгэл, бусад үүрэг хариуцлагын талаар банкны цахим хуудас болон жилийн тайланд тайлагнах;
 - 2.13.5. Компанийн тухай хуулийн 81.5.4-д заасан үнэлгээг жил бүр хийж, үр дүнг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах.
- 2.14. Цалин урамшууллын хороо нь Компанийн тухай хуулийн 81.6-д заасан болон энэ журмын 2.14.1-2.14.4-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
 - 2.14.1. Банкны цалин урамшууллын тогтолцоо, эрсдэлийн соёл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, гүйцэтгэл, хяналтын тогтолцооны талаар бие даасан дүгнэлтийг жилд 1-ээс доошгүй удаа гаргах;
 - 2.14.2. Энэ журмын 2.14.1-д заасан дүгнэлт гаргахдаа гүйцэтгэх удирдлагын урамшууллыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан, гүйцэтгэлд суурилсан эсэхэд хяналт тавьж, жилийн тайланд тайлагнах;
 - 2.14.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх;
 - 2.14.4. ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагад олгосон урамшууллын талаар жилийн тайланд тусгах.
- 2.15. Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4-д заасан болон энэ журмын 2.15.1-2.15.4-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
 - 2.15.1. Гүйцэтгэх удирдлагатай хамтран дотоод аудитын нэгжийг хангалттай хэмжээний ур чадвар, нөөц хараат бус бие даасан эрх мэдлээр хангах ба тус

нэгжийн хүний нөөцийн сонгон шалгаруулалт, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж шаардлагатай тохиолдолд ажлаас чөлөөлөх саналыг ТУЗ-өөр хэлэлцүүлэх;

- 2.15.2. Аудитын тайланд туссан гүйцэтгэх удирдлагын зөрчлийг арилгахад хяналт тавих;
 - 2.15.3. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийг үндэслэн баталсан хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах журмын 3 дугаар зүйлд заасан холбогдох этгээдтэй харилцах бодлого, журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
 - 2.15.4. Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээчээр банкны хяналтын тогтолцоо, банкны нийт эрсдэлийн тогтолцооны үр нөлөөтэй байдлыг хянуулах.
- 2.16. Эрсдэлийн удирдлагын хороо нь энэ журмын 2.16.1-2.16.4-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 2.16.1. Банкны бүх төрлийн эрсдэлийн стратеги, аппетитийг дангаар болон нэгдсэн байдлаар аудитын хороотой хэлэлцэж, ТУЗ-д санал оруулах;
 - 2.16.2. Банкны эрсдэлийн хязгаар, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн соёлыг багтаасан эрсдэлийн цогц бодлогын баримт бичгийг баталж, жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх;
 - 2.16.3. Эрсдэлийн удирдлагын нэгжийн эрсдэл бууруулах төлөвлөгөө, эрсдэлийн хязгаар, эрсдэлийн аппетитийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, банкны одоогийн эрсдэлийн төлөв, эрсдэлийн соёлын талаар тайланг хүлээн авч, хяналт тавих;
 - 2.16.4. Эрсдэл хариуцсан захирал /CRO/-г чөлөөлсөн тохиолдолд олон нийтэд мэдээлнэ. Чөлөөлөх болсон шалтгаан, тайлбарыг ажлын 5 өдрийн дотор Монголбанкинд хүргүүлэх.
- 2.17. Банкны сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай бодлогыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих ба дараах шаардлагыг заавал тусгана:
- 2.17.1. Сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөлүүд, түүнд оролцохоос татгалзах үндэслэл, үүсэхээс сэргийлэх хяналт, хариуцлагын хэлбэр;
 - 2.17.2. Сонирхлын зөрчилтэй аливаа хэлцлийг олон нийтэд ил тод мэдээлэх зохицуулалт.
- 2.18. Монголбанкны хянан шалгагч шаардлагатай гэж үзвэл энэ журмын 2.13.5-д заасан үнэлгээг гаргаж өгнө.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 3.1. Гүйцэтгэх удирдлага нь Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл болон Банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д зааснаас гадна ТУЗ-өөс баталсан эрсдэлийн бодлогын баримт бичиг, бизнесийн стратеги болон цалин урамшууллын бодлого бусад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллахаас гадна дараах үүргийг хүлээнэ:
 - 3.1.1. Дотоод аудит, эрсдэл хариуцсан захирал /CRO/ болон нийцлийн үйл ажиллагаа /комплайнс/-ны бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн ажил үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд саад учруулахгүй дэмжлэг үзүүлж ажиллана.

- 3.1.2. ТУЗ-ийн үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай мэдээллээр хангаж, үүсч болзошгүй дараах асуудлын талаар тогтмол мэдээлнэ. Үүнд:
 - 3.1.2.1. Эрсдэлийн аппетит, эрсдэлийн стратеги, бизнесийн стратегийн өөрчлөлт;
 - 3.1.2.2. Банкны санхүүгийн гүйцэтгэл, санхүүгийн байдал;
 - 3.1.2.3. Холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн, эрсдэлийн хязгаарыг зөрчсөн үйлдлүүд;
 - 3.1.2.4. Дотоод хяналтад гарсан алдаа, дутагдал;
 - 3.1.2.5. Хууль, дүрэм, журмын хэрэгжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээл;
 - 3.1.2.6. Шүгэл үлээх бодлого, журамтай холбоотой асуудлууд.
- 3.2. Банкны тухай хуулийн 34.3-д заасны дагуу гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар зөвшөөрөгдсөн тохиолдолд ТУЗ-ийн эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн байж болох ба бусад хороодын хуралд зөвхөн тус хорооны хүсэлтээр оролцоно.
- 3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийг зөрчсөн, банкны үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулахаар байвал уг үүргийг биелүүлэхээс татгалзан энэ талаар Монголбанканд мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 4.1. Банк нь эрсдэл хариуцсан захирлын /CRO/ удирдлага дор бие даасан, үр дүнтэй эрсдэлийн удирдлагын нэгжтэй байна.
- 4.2. Эрсдэл хариуцсан захирлын эрх, үүрэг шийдвэр гаргалт, хариуцлагын тогтолцоо болон тайлагнах зарчмыг ТУЗ нарийвчлан тогтооно.
- 4.3. Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны бизнесийн үйл ажиллагаа, ашиг олох бүтцээс тусдаа байна.
- 4.4. Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны эрсдэлтэй холбоотой бүх үйл ажиллагааг хариуцах бөгөөд дараах үүргийг биелүүлж ажиллана. Үүнд:
 - 4.4.1. Учирч болзошгүй эрсдэлийг банкны нэгдэл, салбар нэгж, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийх;
 - 4.4.2. Томоохон харилцагчийн үйл ажиллагааны онцлог, салбар нэгж болон бизнесийн чиглэл бүрээр эрсдэлийг үнэлэх;
 - 4.4.3. Банкны хөрвөх чадвар, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж улмаар нэгж тус бүрд учирч болох эрсдэлийн дүгнэлт гаргаж, шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 4.4.4. Банкны үйл ажиллагааны чиглэл тус бүрээр газар, хэлтсийн хооронд мэдээлэл солилцох, мэдээллийн хэвтээ бүтэц, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангах, мэдээллийн шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 4.4.5. Эрсдэлийн аппетит, эрсдэлийн хязгаар нь банкны өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын эрсдэлийн бүтэцтэй нийцэж буй эсэхэд хяналт тавих;

- 4.4.6. Банкны эрсдэлийн соёл, аппетит болон хязгаар зэрэг эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах;
- 4.4.7. Банкны эрсдэлтэй үйл ажиллагаанууд болон эрсдэлд өртөх байдалд байнгын хяналт тавьж, материаллаг эрсдэлийн түвшнийг тодорхойлох;
- 4.4.8. Эрсдэлийн хязгаарыг давсан тохиолдолд урьдчилан сануулах болон хязгаарлалт тогтоох системийг бий болгох;
- 4.4.9. Банкны шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх болон бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахад эрсдэлийн төлөвийг үнэлэх;
- 4.4.10. Стресс тест, сценарь шинжилгээ болон одоогийн стратеги, загвар нь өмнөх гүйцэтгэлд хэр зэрэг үр дүнтэй байсан /backtesting/-ыг шалгах замаар гүйцэтгэл болон эрсдэлийн үнэлгээг хийх;
- 4.4.11. Дээрх асуудлаар болон эрсдэлийг удирдах, бууруулах бусад санал, зөвлөмжийг гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар танилцуулах;
- 4.4.12. Банкны эрсдэлийн удирдлагын мэдээлэл технологийн дэд бүтцийн цогц, тасралтгүй байдлаар хөгжүүлэх нөхцөлийг хангаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

ТАВ.НИЙЦЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА /КОМПЛАЙНС/

- 5.1. ТУЗ нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ зохих хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа шударгаар явуулж, хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих хараат бус бие даасан Комплайнсын чиг үүрэг бүхий нэгж, удирдлагыг томилно.
- 5.2. Комплайнсын нэгж нь эрсдэлийн удирдлагын нэгж болон дотоод аудитын нэгжтэй адил банкны дотоод мэдээллийн системд нэвтрэх эрх, хүний нөөц, төсөв хөрөнгө, үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллээр хангагдах эрхтэй байна.
- 5.3. Комплайнсын нэгж нь хууль, тогтоомж эрх зүйн акт болон банкны дотоод дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулахаас гадна ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулж эрсдэлийг соёлыг төлөвшүүлнэ.
- 5.4. Комплайнсын нэгж нь энэ журмын 2.4.2-д заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн, зөрчиж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг нэн даруй мэдээлэх шүтэл үлээгчийн бодлогыг хэрэгжүүлж дараах байдлаар хяналт тавина. Үүнд:
 - 5.4.1. Шүтэл үлээгчийг цаашид гадуурхагдах, эрх нь зөрчигдөх асуудлаас хамгаалж, нууцыг хадгална.
 - 5.4.2. Ёс зүйн дүрэм зөрчсөн мэдээллийг хянаж үзэн холбогдох саналыг гүйцэтгэх удирдлагад шилжүүлж, шийдвэрлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-д хүргүүлнэ.
- 5.5. Комплайнсын нэгж нь зохицуулагч байгууллагаас шаардсан баримт, тайлан мэдээг цаг хугацаанд нь бэлтгэж, хүргүүлэх ба хамтарсан уулзалт, ярилцлага, хэлэлцүүлгийг зохион байгуулж хамтарч ажиллана.

ЗУРГАА. ДОТООД АУДИТ

- 6.1. Дотоод аудитын нэгж нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан үйл ажиллагаанаас гадна банкны эрсдэл хариуцсан нэгж болон комплайнсын үр дүнтэй байдал, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад тайлагнаж буй эрсдэлийн тайлангийн чанар, комплайнсын хэрэгжилт, дотоод хяналтын тогтолцоог тогтмол бие даан үнэлж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг хараат бус бодит нотлох баримтаар хангана.
- 6.2. Дотоод аудитын тайланг ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар тайлагнах, хараат бус бие даасан эрхтэй байна.
- 6.3. Дотоод аудитын нэгжийн захирал эсхүл дотоод аудиторыг ажлаас чөлөөлсөн тохиолдолд олон нийтэд мэдээлж, чөлөөлөх болсон шалтгаан, тайлбарыг ажлын 5 өдрийн дотор Монголбанкинд ирүүлнэ.

ДОЛОО. ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

- 7.1. Монголбанк банканд зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангахад Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан шаардлагаас гадна дараах мэдээллийг банкны цахим хуудсаар тайлагнасан эсэхийг хянан шалгана. Үүнд:
 - 7.1.1. Банкны эрхэм зорилго, хэтийн зорилт;
 - 7.1.2. Банкны толгой компани, банкны нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн үйл ажиллагааны талаар;
 - 7.1.3. Банкны тухай хуулийн 38.2.4 дэх хэсэгт заасан этгээдийн нэрс, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлагын талаар;
 - 7.1.4. Банкны толгой компани, тэдгээрийн зэргэлдээ компанийн засаглалын зарчмын талаар;
 - 7.1.5. ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар баталгаажуулсан жилийн тайланд банкны нийгмийн хариуцлагын талаар;
 - 7.1.6. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах бодлого, журам;
 - 7.1.7. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бодлого, журам, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ;
 - 7.1.8. Цалин, урамшууллын бодлого;
 - 7.1.9. Эрсдэл хариуцсан захирал /CRO/ болон дотоод аудитын нэгжийн удирдлагыг томилсон, чөлөөлсөн талаар шийдвэр;
 - 7.1.10. ТУЗ-ийн хараат бус гишүүний Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-д заасан журмын дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан;
 - 7.1.11. Энэ журмын 2.17.2-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл болон холбогдох этгээдтэй хийсэн гэрээ, хэлцэл.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ

Найм. Үнэлгээний зарчим

- 8.1. “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн үнэлэх үнэлгээний загвар”-ыг дараах байдлаар үнэлнэ:
 - 8.1.1. Биелэлтийг үнэлэхдээ асуулт тус бүрийн хувьд бүрэн биелсэн бол 2, хагас биелсэн бол 1, биелээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлж, холбогдох тайлбарыг ирүүлнэ.
- 8.2. Хянан шалгагч Нэгдсэн үнэлгээний дүнгээс хамаарч банкны зохистой засаглалын журмын хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:
 - 8.2.1. Нэгдсэн үнэлгээ 80 оноогоос дээш байвал сайн засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаа хэвийн;
 - 8.2.2. Нэгдсэн үнэлгээ 65-79 оноо байвал дунд засаглалтай буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд асуудал үүсч болзошгүй;
 - 8.2.3. Нэгдсэн үнэлгээ 50-64 оноо байвал хангалтгүй засаглалтай буюу банкинд хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;
 - 8.2.4. Нэгдсэн үнэлгээ 49 оноогоос доош байвал муу засаглалтай банк буюу банкны удирдлагын үйл ажиллагаанд албадлагын арга хэмжээ авах үндэслэл болно.
- 8.3. Бүх асуултын хариултын оноог нэмэхэд хамгийн дээд оноо 100 байх ба үнэлгээний хувийг дараах байдлаар гаргана:

$$\text{Үнэлгээ (\%)} = \frac{\text{Авсан оноо}}{100} \times 100$$

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

ЕС. БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

- 9.1. Монголбанкны хянан шалгагч Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн үнэлэх үнэлгээний загварыг үнэлэхдээ банкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, эрсдэл хариуцсан захирал, комплайнс, дотоод аудитын нэгжтэй тогтмол харилцах ба зөрчил дутагдал гарсан тохиолдолд Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
- 9.2. Хянан шалгагч энэхүү журмын дагуу банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн үнэлгээг Банкны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан холбогдох баримт бичгээр баталгаажуулна.
- 9.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл түүний ажлын алба нь хурлын тэмдэглэлийн шийдвэрлэсэн асуудлын хураангуй, гишүүдийн санал болгосон шийдвэр, саналын зөрүүтэй, хэлэлцүүлгийн шинжтэй хураангуйг тусгайлан тэмдэглэх ба хянан шалгагчийн шаардлагаар тухай бүр гаргаж өгнө.
- 9.4. Хянан шалгагч энэ журам болон журмын нэгдүгээр хавсралтад заасан үнэлгээний загварын дагуу баталсан бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг баталгаажуулахын тулд энэ журмын 9.1-д заасан албан тушаалтануудтай уулзалт, ярилцлага болон цахимаар нотлох баримтыг тухайн жилийн турш байнгын /ongoing supervision/ бүрдүүлж, үнэлгээний хариуг жил бүрийн 2 дугаар сарын 28-ний өдрийн дотор эцэслэн гарган банканд хүргүүлнэ.